



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 436

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар" төрийн өмчит үйлдвэрийн газрын хөрөнгөд бүртгэлтэй 107,904,000.00 (нэг зуун долоон сая есөн зуун дөрвөн мянга) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан биет бус хөрөнгө (843 м.кв газар эзэмших эрх)-ийг Экологийн цагдаагийн албанд балансаас балансад шилжүүлсүгэй.

2."Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар" төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Ичинхорлоо, Экологийн цагдаагийн албаны дарга Ш.Цогбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрын 2021 оны 10
дугаар сарын 19-ний өдрийн 186
дүгээр тогтоолын хавсралт

"ДБҮЭГ" ТӨҮГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Экологийн Цагдаагийн
албанд шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, байршил	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын нийт үнэ (төгрөг)
1	Биет бус хөрөнгө, газар эзэмших эрх (Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 7-р хороо)	2018	м.кв	843	107,904,000.00
	Нийт дүн				107,904,000.00 (нэг зуун долоон сая есөн зуун дөрвөн мянга)